Тус байгууллага нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Шилэн дансны тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт оржээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/83 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Ховд аймгийн Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах санал дүгнэлтийг гаргажээ.

2022 онд Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас 2021 он 2022 оны эхний 8 сарын үйл ажиллагаанд хяналт шалгалт, Авлигатай тэмцэх газраас мөн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөвлөмж өгсөн байна.

Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалтаар Засаг даргын нөөц хөрөнгийг хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулах, урьдчилан төлөвлөж урсгал зардлаар хийж болох үйл ажиллагааг санхүүжүүлдэг зөрчил дутагдлыг таслан зогсоох, давтан гаргахгүй байх, төсвийг

хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, хяналт хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авах зөвлөмж өгсөн байна.

Шалгалтаар Засаг даргын Тамгын газартай холбоотой илэрсэн зөрчлүүдээс дурдал:

Засаг даргын нөөц хөрөнгөөс гарын бэлэг бэлтгэх, ресторан зоогийн газарт хооллох, зочид буудалд байрлах төлбөрийг нь төлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 33 дугаар тушаалаар “Сум багийн хөгжлийг дэмжих, чадавжуулах хөтөлбөр арга хэмжээ”-нд зориулсан 500.0 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулах эрхийг Ховд аймгийн Засаг даргад шилжүүлсэн байх бөгөөд уг хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал, зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасныг зөрчиж, 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр “Манхан тур” ХХК-ийн данс руу “Байгаль нуурын аяллын зардал /21 хүний/-д 12,600,000 төгрөг, 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр “Мөнх жаргалант” ХХК-ийн дансанд “7 хүн 3 хоног зочид буудалд байрласны төлбөр” 3,780,000 төгрөг, 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр “Мөнх жаргалант” ХХК-ийн дансанд “ресторанаар үйлчлүүлсний төлбөр” 1,450,000 төгрөг, 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдөр “Санжэм” ХХК-ийн дансанд “ресторанаар үйлчлүүлсний төлбөр” 988,500 төгрөг, 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр “Ажнай сүрэг” ХХК-ийн дансанд “8 сумын 35 хүний хээрийн хоол ундны үйлчилгээний төлбөр” 7,500,000 төгрөгийг тус тус шилжүүлж зарцуулсныг тогтоосон байна.

Харин Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас хийсэн хяналт, шалгалтаар автомашины хувийн хэрэгт 10.2 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийн зарцуулалтыг хөтөлж, баяжилт хийгээгүй, бензин шатахууны анхан шатны баримтын бүрдэл дутуу, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт бичээгүй, гарын үсэг зуруулаагүй зэрэг зөрчлийг илрүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 205.4 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|--|---------------------|----------------------|--------------------|
| | Эхний үлдэгдэл 1 | Эцсийн үлдэгдэл 2 | Өөрчлөлт 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 1,414,658.7 | 1,102,226.6 | (312,432.1) |
| Бараа материал | 508,463.6 | 677,677.0 | 169,213.4 |
| Үндсэн хөрөнгө | 4,232,529.8 | 4,170,303.5 | (62,226.3) |
| Нийт хөрөнгө | 6,155,652.1 | 5,950,207.1 | (205,445.0) |
| Өр төлбөр | - | 16,954.7 | 16,954.7 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 6,155,652.1 | 5,933,252.4 | (222,399.7) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 6,155,652.1 | 5,950,207.1 | (205,445.0) |

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх авлагын дүн өмнөх оноос 312,432.1 мянган төгрөгөөр буурсны материаллаг нөлөө нь үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Тайлант онд 5,684.1 сая төгрөгийн мөнгөн орлогыг бүрдүүлэн зарцуулж оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.
- ✓ Авлага оны эхэнд 1,414.7 сая төгрөг байсан бол оны эцэст 1,102.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өнгөрсөн оны 1,205.1 сая төгрөгийн өмнөх оны санхүүжилтийн авлага буурч, энэ онд 190.1 сая төгрөгийн төвлөрүүлэлтийн авлага, өвс, тэжээлтэй холбоотой 160.0 сая төгрөг, орон нутагт хэрэгжүүлж буй бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрт урьдчилж гарсан 595.8 сая төгрөг зэрэг авлагыг бүртгэсэн байна.
- ✓ Бараа материал 508.5 сая төгрөг байсан бол 677.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус онд 636,2 сая төгрөгийн материал нэмэгдэж, 779.8 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 55.9 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөөр шилжүүлэн бүртгэсэн байна.
- ✓ Оны эхэнд өр төлбөргүй байсан бол оны эцэст 16.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь цалин хөлстэй холбоотой 1.8 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчид төлөх 15.1 сая төгрөгийн өглөгтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,624.4 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 20.0 сая төгрөг нийт 2,644.4 төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 368.1 сая төгрөгөөр бууруулж, 2,276.3 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 41.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,298.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, туслах үйл ажиллагааны орлогоос 20.0 сая төгрөг нийт 2,318.1 сая төгрөг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,298.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоос 17.6 сая төгрөг, нийт 2,315.7 сая төгрөг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,315.7 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2.4 сая төгрөгөөр тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--------------------|--|--------------------|--------------------|----------------|-------------|
| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| 1 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / үндсэн үйл ажиллагаа 70106/80101 | 1,221,915.2 | 1,222,513.9 | 2,401.3 | 99.8 |
| 2 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ 70106/80103 | 311,708.9 | 311,708.9 | 0 | 100 |
| 3 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / мэдээлэл сурталчилгааны зардал 70106/80205 | 4,982.0 | 4,982.0 | 0 | 100 |
| 4 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / харуул хамгаалалт 70106/80219 | 23,000.0 | 23,000.0 | 0 | 100 |
| 5 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / ажил олгогчоос олгох тэтгэмж, дэмжлэг урамшуулал 70106/80802 | 31,244.8 | 31,244.8 | 0 | 100 |
| 6 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / орон нутгийн нөөц хөрөнгө 70106/81102 | 722,201.0 | 722,201.0 | 0 | 100 |
| ДҮН | | 2,318,081.9 | 2,315,680.6 | 2,401.3 | 99.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс 579.4 сая төгрөг, хөшөөт хөгжил сангийн санхүүжилтээр 367.7 сая төгрөг, Техник хяналтын зардлын данснаас 16.1 сая төгрөг, Засаг дарга данснаас 60.4 сая, өмнөх оны үлдэгдлээс 1,243.4 сая төгрөг, төрийн албаны зөвлөлөөс 6.2 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 31.5 сая төгрөг, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас эрх шилжсэн арга хэмжээнд 500.0 сая төгрөг, Батлан хамгаалах яамнаас 2.2 сая төгрөг, Архивын ерөнхий газрын санхүүжилт 18.3 сая төгрөг, өвс тэжээлийн үнэ 73.3 сая төгрөг, гурилын үнэ 100.0 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн байгууллагаас 33.5 сая төгрөг, онцгой байдлын ерөнхий газраас 1.2 сая төгрөг, хандив тусламжаар 95.1 сая төгрөг, үндсэн данснаас 240.1 сая төгрөг, нийт 3,368.4 сая төгрөг бүрдүүлж, 3,178.3 сая төгрөгийг зарцуулж 190.1 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Бадрал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 2/278 албан бичгээр ирүүлсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярсүх нь аймгийн Засаг даргын захирамжаар байгууллага, сумдын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсгийн ахлагчаар, аймгийн аварга малчид тариаланчдын шагнал гардуулах зэрэг ажлуудаар хөдөө сумдаар ажилласан тул санхүүгийн тайланд гарын үсэг зурагдалгүй хүлээгдсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,859.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 48.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 38.9 сая төгрөгөөр тогтоосныг шинэчлэн 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,706.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 47.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 37.7 сая төгрөгөөр тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зарим зардлуудыг санхүүжүүлсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч даргатай холбоотойгоор аймгийн Засаг даргын 1 орлогчийг жолооч, туслах ажилтны хамт 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс чөлөөлсөн байна.

6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэлтэй холбоотойгоор нийт 131.7 сая төгрөгийн шатахуун зарцуулсан ба үүнээс аймгийн Засаг дарга 33.9 сая төгрөгийн шатахуун зарцуулсан бөгөөд бусад автомашинд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 69.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан. Энэ нь цэргийн дүйцүүлэх сургалт, цэрэг

татлагын комисс, 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн бэлтгэх, тэсэрч дэлбэрэх бодис хайх, сум багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр сургалт, баруун бүсийн даншиг наадмын комисс, цэргийн “Дөл” тэмцээн, Цайны зам өв соёлын наадам, Сумдад үзлэгээр ажилласан Эмч нарын зардал, 2022 оны мал тооллого, түр хорооны ажлын хэсэг, сумдад томилолтоор ажиллах, үйлчилгээнд хот дотор ажилласан, хяналтаар аймаг сумдад ажиллах, сургалт семинараар Улаанбаатар хотод ажиллах, баруун хил боомтоор ажиллах, баяр наадмын комисс ажиллах, 16 сумдад ажиллах, баруун аймгуудад ажиллах зэрэг үйл ажиллагаанд зарцуулж автомашин хэрэглэсэн байна.

7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой тус газраас зардал гараагүй байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд 39.4 сая төгрөгийн томилолтын зардлыг 48 албан хаагчид олгосон байна. Энэ нь Засаг дарга болон бусад албан хаагчид Улаанбаатар хот, аймаг, сумдад ажилласантай холбоотой байна. Харин Засаг даргын нөөц хөрөнгө болон хөтөлбөр арга хэмжээний мөнгөнөөс 17.4 сая төгрөгийн хоол, буудлын төлбөрийг төлсөн байна.

11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн хувьд тэтгэвэрт гарсан 1 төрийн үйлчилгээний 17.6 сая төгрөгийн тэтгэмжийг төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасны дагуу олгосон байна.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжтай холбоотой хэвлэл захиалгын зардалд 0.6 сая төгрөг зарцуулсан бөгөөд энэ нь Төрийн мэдээлэл эмхэтгэл байна.

15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотойгоор дараах зардлууд гарсан байна. Үүнд: эмээл, мөнгөн аяга, бэлэг дурсгалын зүйлстэй холбоотой 20.1 сая төгрөг зарцуулжээ.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалттай холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна.

Энэ хуулийн хүрээнд Засаг даргын орлогч, туслах, жолоочийн орон тоог хассанаар 18.8 сая төгрөгийн цалинтай холбоотой зардал, албан тушаалын автомашинтай холбоотой 4.7 сая төгрөгийн сэлбэг, шатахууны зардал, нийт 23.5 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 19 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар цалингийн зардал зөрүүтэй илэрхийлэгдсэн, НДШ-ийн тооцоо зөрүүтэй, хүн амын орлогын албан татвар суутгаж аваад төсөвт төлөөгүй 5.5 сая төгрөг, цэргийн хэлтсийн ажилчдын онцгой нэмэгдлийг журмын дагуу олгоогүй 4.5 сая төгрөг, түрээсийн орлогын 40%-ийг бүрэн төвлөрүүлээгүй 960.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж төлбөрийн акт тогтоосноос 6.7 сая төгрөгийг барагдуулж 4.5 сая төгрөг барагдаагүй байна.

Захирамжийн биелэлт, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт хангалтгүй 207.4 сая төгрөг, насжилт өндөртэй авлага бууруулаагүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, өмнөх онуудын нөөцийн мах, өвсний тооцоо хангалтгүй хийгдсэн 213.8 сая төгрөг, албан өрөөг төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгж байгууллагууд түрээсэлж байгаа албан өрөөний түрээсийн төлбөрөө бүрэн төлөөгүй, орон сууцны ашиглалтын гэрээ байхгүй шаардлагатай албан тушаалтныг байраар хангаагүй 30.8 сая төгрөг, хөрөнгөнд бүртгэлтэй приус маркийн автомашин биетээр байхгүй хөрөнгө шилжүүлэх шийдвэр гараагүй байхад Эрүүл мэндийн даатгалын хэлтэст ашиглагдаж хөрөнгийн үр ашиг буурсан 17.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж албан шаардлага өгсөн байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд автомашин шилжүүлэх санал оруулсан боловч 2022 онд шийдвэрлэгдээгүй байна.

Шатахууны зардлын тооцоог норм нормативаар нь бодоогүй, хот дотор явж байгаа шатахууны зардал хэмнэгдээгүй, машин унах эрх бүхий албан тушаалтны жишиг норм баримтлаагүй, дотоод хяналт сул, Засгийн газрын 43-р тогтоолоор төсвийн хэмнэлт гаргаж 10-аас доошгүй хувийг төсөвт төвлөрүүлээгүй 320.6 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчдийн хоорондын тооцоо зөрүүтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй кассаар их хэмжээний мөнгө зарцуулаад мөнгөн кассын журам баримтлаагүй 218.5 сая төгрөг, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмч хамгаалах комиссын дотоод хяналт сул, бараа материалын дансанд үндсэн хөрөнгө болох хөрөнгүүд бүртгэлтэй, хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу ангилж бүртгээгүй шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн 176.4 сая төгрөг зэрэг зөрчил илрүүлж, зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|----------|--------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 11.2 | 1 | 6.7 | 60 |
| Албан шаардлага | 2 | 469.6 | 2 | 452.1 | 96.3 |
| Зөвлөмж | 4 | 715.5 | 3 | 497.0 | 69.5 |
| Нийт дүн | 8 | 1,196.3 | 6 | 955.8 | 79.9 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар шатахууны тооцоо, нэмэлт дансны зарцуулалт, өвсний тооцоо, “Хан алтайн дуулал” цогцолборын суурийн барилга 226.3 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг баримт бичгийг бүрдүүлэн бүртгэн авсан эсэхийг авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 335.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 335.2 сая төгрөгийн алдааг залруулав.

Үүнд: Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт орлогыг илүү тусган илэрхийлсэн, Нийтийн бие засах газар хийхээр 40.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд бараа материалд материал тус бүрээр орлого авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалын хавсралтаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.26-д "Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ хийхэд улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-17 "Үндсэн хөрөнгө"-ийг дагаж мөрдөнө." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу залруулсан болно.

Аудитаар нийт 235.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 46.1 сая төгрөгийн 4 зөвлөмж, 189.8 сая төгрөгийн 3 албан шаардлага өгсөн.

5.1 Албан шаардлага

5.1.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

- 2022 онд эмээл, бэлэг дурсгал, бялуу, бэлгийн тор, бэлэг дурсгалын зураг, мөнгөн аяга гэх зэрэг бэлэг дурсгалын зүйлд 20.1 сая төгрөг төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;"-ыг хориглоно гэснийг зөрчиж байна.
- Сайд, дэд сайд, бусад албаны хүмүүс сургалт, хэлэлцүүлэг, бусад цаг үеийн ажлуудаар ажиллахад 17.4 сая төгрөгийн хоол, буудлын мөнгийг төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9.3-д "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно", 15.2.3-д "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг зөрчиж байна.

Шийдвэрлэлт:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн үргүй зардал гаргаж зориулалт бус зарцуулахыг таслан зогсоох албан шаардлага бичлээ.

5.1.2 Анхан шатны баримт, зарцуулалтын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Засаг даргын А/537 дугаар захирамжаар ЗГХЭГ-н эрх шилжүүлсэн Сум багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр арга хэмжээнээс Ногоон стандарт ХХК-д 19.5 сая төгрөг, Мон тун

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

фарм ХХК-д 10.7 сая төгрөг, Арван улиас ХХК-д-10.0 сая төгрөг, Медуса ХХК-д-12.0 сая төгрөг шилжүүлсэн боловч хэрэгжүүлсэн ажлын тайлан байхгүй, ямар ажил хэрэгжүүлсэн нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, анхан шатны баримт, гэрээ, гүйцэтгэлийн баримтуудыг бүрэн хүлээн авах, баримтгүй гүйлгээг тусгаж байгааг таслан зогсоох албан шаардлага бичлээ.

5.1.3 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Засаг даргын А/210 захирамжаар тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 100.0 сая төгрөгийн зарцуулах эрх, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах эрхийг Засаг даргын Тамгын газрын даргад шилжүүлсэн бөгөөд уг ажлыг гүйцэтгэхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгээчийг сонгож гэрээ байгуулна", "7.1.1-д нээлттэй тендер шалгаруулалтын журам", 46.1.4-д "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;" , Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ" тогтоосныг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ажиллаж байх албан шаардлага бичлээ

5.2 Зөвлөмж

5.2.1 Анхан шатны баримт, зарцуулалтын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайлан мэдээ бүрэн гаргаагүйтэй холбоотой доорх зөрчлүүд илрэв. Үүнд:

- Өмнөд Экватор улсын уран бүтээлчидтэй туршлага солилцох зорилгоор А/571 захирамжаар 9.4 сая төгрөг зарцуулахдаа гэрээ байгуулаагүй, тайлан мэдээ гаргаагүй.
- Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, үндэсний их баяр наадмын морь, бөхийн бай шагналд 20.1 сая төгрөг зарцуулсны тайлан, анхан шатны баримтын бүрдэл хангаагдаагүй байгаа нь зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д

"батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэснийг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвөөс зарцуулж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний анхан шатны баримт, гэрээ, гүйцэтгэлийн баримтуудыг бүрэн хүлээн авах, баримтгүй гүйлгээг тусгахгүй байх.

5.2.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын А/780 захирамжаар архив бичиг хэрэг, дотоод ажилтнуудын сургалт зохион байгуулахдаа захирамжид тусгагдсан зардлаас өөр буюу цайны зардалд 1.1 сая төгрөг зарцуулсан. Мөн А/63, А/244 захирамжуудаар хөрөнгө зарцуулахдаа захирамжаас зөрүүтэй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэснийг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө мөнгө зарцуулахдаа Засаг даргын захирамжийн хүрээнд батлагдсан зориулалтын дагуу зарцуулах.

5.2.3 Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ажилтнуудад түлшний хөнгөлөлт 1.2 сая төгрөг олгохдоо НДШ суутгаагүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.1.4-д "аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого"-д шимтгэл ногдуулна гэснийг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт олгох тохиолдолд хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах.

5.1.4 Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

А/537 захирамж ЗГХЭГ-н эрх шилжүүлсэн Сум багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр арга хэмжээнээс цагдаагийн газрын аялалд 14.3 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д "Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "Хуулиар зөвшөөрөөгүй бусад" зүйлд зарцуулахыг хориглоно гэснийг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Хөтөлбөр, арга хэмжээнд тусгагдсан ажлуудад төсвийн хөрөнгийг зарцуулах. Төрийн байгууллагын аялал, зугаалга, тэмцээн, уралдаантай холбоотой зардлыг санхүүжүүлэхгүй байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|------------------|-----------------------------------|-----|--------------------------|------------------|------------|------------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг илүү тусган илэрхийлсэн. | 1 | 295,225.3 | | | 1 | 295,225.3 | 1 | 295,225.3 | | | | |
| Хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн | 1 | 40,000.0 | | | 1 | 40,000.0 | 1 | 40,000.0 | | | | |
| Дүн | 2 | 335,225.3 | | | 2 | 335,225.3 | 2 | 335,225.3 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|----------|-----------------|--------------------------------------|---------------------|---|----------|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй | 1 | 100,000.0 | | | 1 | 100,000.0 | | | | | | |
| Баримтын бүрдэл дутуу, ямар ажил хэрэгжүүлсэн нь тодорхойгүйгээр шууд зардалд бүртгэсэн | 1 | 52,250.0 | | | 1 | 52,250.0 | | | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайлан мэдээ бүрэн гаргаагүйтэй | 1 | 29,535.1 | | | | | 1 | 29,535.1 | | | | |
| Хөрөнгө мөнгө зарцуулахдаа Засаг даргын захирамжийн хүрээнд батлагдсан зориулалтын дагуу зарцуулаагүй | 1 | 1,050.0 | | | | | 1 | 1,050.0 | | | | |
| Ажилтнуудад түлшний хөнгөлөлт олгохдоо НДШ суутгаагүй | 1 | 1,200.0 | | | | | 1 | 1,200.0 | | | | |
| Аялал, зугаалга, тэмцээнд хөрөнгө зарцуулсан | 1 | 14,298.0 | | | | | 1 | 14,298.0 | | | | |
| Дүн | 6 | 198,333.1 | | | 2 | 152,250.0 | 4 | 46,083.1 | 0 | 0 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Бэлэг дурсгал, бусад байгууллагын албан хаагчдын буудал хоолны зардлыг төсвөөс | 1 | 37,545.2 | | | 1 | 37,545.2 | | |
| Дүн | 1 | 37,545.2 | | | 1 | 37,545.2 | | |
| Нийт дүн | 1 | 37,545.2 | | | 1 | 37,545.2 | | |


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:



Ц.БАДРАЛ